



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/356

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар дүгнэлтийн дагуу Богд, Бүрд, Арвайхээр хотын Тэмүүлэл-Эрдэм, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Хархорин сумын гүнзгийн сургуульд физик, Богд сумын 1, 2 дугаар сургууль, Бүрд, Төгрөг, Уянга сумын 1 сургууль, Хайрхандулаан, Хархорин 2 дугаар сургууль болон гүнзгийн, Номын хүрдэн сургуулиудад химийн кабинетийн тоног төхөөрөмж худалдан авах тендерийн 1 дүгээр багц Богд, Бүрд, Арвайхээр хотын Тэмүүлэл-Эрдэм, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Хархорин сумын гүнзгий сургуульд физикийн кабинетыг 58,818,900 (тавин найман сая найман зуун арван найман мянга есөн зуу) төгрөгөөр Хашхан ХХК-иар, 2 дугаар багц Богд сумын 1, 2 дугаар сургууль, Бүрд, Төгрөг, Уянга сумын 1 дүгээр сургууль, Хайрхандулаан, Хархорин сумын 2 дугаар сургууль болон Гүнзгий, Номын хүрдэн сургуулиудад химийн кабинетыг 73,789,980 (далан гурван сая долоон зуун наян есөн мянга есөн зуун наян) төгрөгөөр Голденхоул ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгжид гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0688

D:My Doc. Zahiramj. Zasag darga